



## САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2019 оны 5 сарын 23-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

### Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөс “Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл”-тэй холбогдуулан гаргасан зөвлөмж:

Энэхүү хуулийн төслийг одоогийн хэлбэрээр батлан мөрдүүлэх тохиолдолд санхүүгийн салбарт бий болох эрсдэлийг харгалзан санхүүгийн зуучлал, хүртээмжтэй байдлыг сайжруулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах зорилгоор дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Хуулиар зээлийн хүүний дээд хязгаар тогтоох нь олон сөрөг үр дагаварт хүргэдгийг олон улсын туршлага харуулж байна. Зээлийн хүүний дээд хязгаарыг хатуу тогтоох нь жижиг, дунд бизнес эрхлэгч, бага орлоготой иргэд болон орон нутгийн зээлдэгчдэд хүрэх зээлийн үйлчилгээг хумьж, хүртээмжийг бууруулж, эргээд албан бус зээлийн үйлчилгээ хөгжих нөхцөлийг бий болгох, санхүүгийн байгууллагуудын шимтгэл өсөх зэрэг үр дагаварт хүргэх эрсдэлтэй.

Хоёр. Монгол Улс эдийн засгийн дунд хугацааны сорилтуудаа амжилттай даван туулахад олон улсын санхүүгийн байгууллагууд, донорууд болон гадаадын хөрөнгө оруулагчдын дэмжлэг, итгэлцэл чухал хэвээр байна. Хууль тогтоох байгууллагаас зах зээлд зээлийн хүү тогтох тогтолцоонд шууд оролцож, чөлөөт эдийн засгийн зарчмаас ухрах нь олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, чиглэлтэй харшлахын зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгод ч сөргөөр нөлөөлөх болно.

Гурав. Зээлийн хүүг зах зээлийн зарчмаар бууруулах нь зүйтэй. Энэ хүрээнд эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх замаар зээлийн хүүг зах зээлийн зарчимд тулгуурлан бууруулах зорилготой боловсруулж, СТБЗ-өөс 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдөр баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг тууштай хэрэгжүүлэх нь чухал боллоо.

Дөрөв. Мөнгө хүүлэлтийн эсрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурал (УИХ)-д өргөн барихад бэлэн болоод байгаа “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийн төслийг хэлэлцэж батлах нь чухал гэж үзэж байна. Тус хуулийн төсөлд мөнгө хүүлэлт, түүнтэй тэмцэх зохицуулалтыг тусгах болно.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨРЧ

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ  
ДАРГА

САНГИЙН САЙД

ХАДГАЛАМЖИЙН  
ДААТГАЛЫН  
КОРПОРАЦИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.БАЯРТСАЛХАН

С.ДАВАДСҮРЭН

Ч.ХҮРЭЛБААТАР

Х.БУМ-ЭРДЭНЭ

УЛААНБААТАР ХОТ ТТЗ/955-Д: 8108934